БАТЛАВ.
ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА,
ДОТООДЫН ЦЭРГИЙН КОМАНДЛАГЧ,
ХОШУУЧ ГЕНЕРАЛ Ж.БОЛД

2023 оны 03 дугаар сарын 07 -ны өдөр

# ЦАГДАА, ДОТООДЫН ЦЭРГИЙН АНГИ, БАЙГУУЛЛАГЫН 2023 ОНЫ АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨЛТ

2023 оны 03 дугаар сарын 07-ны өдөр. Улаанбаатар хот.

| № | Зорилтын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа | Үйл ажиллагааг хэрэгжүүлэх арга хэмжээ | Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт | Хэрэгжих хугацаа | Хариуцан хэрэгжүүлэх | Хамтран хэрэгжүүлэх |
|---|---|---|---|---|---|---|
| *Зорилт-1: Хууль тогтоомжийг сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр* | | | | | | |
| 1. | Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх. | 1.1.Авлигатай тэмцэх газраас бэлтгэсэн тв шторк, инфографик, видео график, нийтлэл, теле зохиомж, хөдөлгөөнт зураг, зурагт хуудас, цахим ном, гарын авлага зэргийг тухайн орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ (фэйсбүүк, твиттер, youtube суваг), мөн лед дэлгэц, сурталчилгааны самбарт байршуулах зэрэг бүхий л боломжтой хэлбэрээр иргэд, олон нийтэд хүргэх. | -Баримтжуулж, үр дүнг нотломжийн хамт тайлагнасан байх. | Тухай бүр | Хэвлэл мэдээллийн төв | Нутаг дэвсгэр хариуцсан цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллага |
| | | 1.2.Авлигын эсрэг нөлөөллийн арга хэмжээг нутаг дэвсгэрийн нэгж, байгууллага, салбарын онцлогт тохируулан зохион байгуулах. | - Байгууллага бүр 2-оос доошгүй өдөрлөг, нөлөөллийн үйл | | Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй | ЦДЦАБ |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | 1.3.Авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчлах “Шударга ёс, хөгжил дэвшилд 110” мэдээллийн самбар ажиллуулах. | -Мэдээллийг тогтмол шинэчлэх ажлыг хэвшүүлсэн байх.<br>- Авлигатай тэмцэх газраас хүргүүлсэн мэдээллийг байршуулсан байх. | Байнга | Эрүүгийн цагдаагийн алба | ЦДЦАБ |
| | | 1.4. Өөрсдийн үйл ажиллагааг авлигын эрсдэлээс ангид байхад чиглэсэн ёс зүй, шударга байдлыг уриалсан агуулга бүхий сурталчилгааг хийж олон нийтэд хүргэсэн байх. | - Байгууллага бүр 2-оос доошгүй сурталчилгааны материал боловсруулсан байх.<br>-Сурталчилгааны материалдаа 110 дугаарыг оруулж, боломжит бүх хэлбэрээр олон нийтэд хүргэсэн байх. | Байнга | Урьдчилан сэргийлэх хэлтэс | Албад |
| *Зорилт-2: Авлигын эсрэг сургалт зохион байгуулах чиглэлээр* | | | | | | |
| 2. | Албан хаагчдыг Авлигатай тэмцэх газраас зохион байгуулах сургалтад хамруулах. | 2.1.Шинээр томилогдсон алба хаагчдыг авлигын эсрэг сургалтад хамруулсан байх. | -Сургалтад хамрагдсан алба хаагчийн тоо. | Тухай бүр | Дотоод хяналт-Аюулгүй байдлын газар | ЦДЦАБ |
| | | 2.2.Авлигын эсрэг сургагч багш нарын давтан сургалтыг зохион байгуулах, алба хаагчдадаа зохион байгуулсан сургалтын дүнг тооцох. | -Сургалт зохион байгуулсан байх.<br>-Хамрагдсан алба хаагчийн тоо. | Жилдээ | Сургалтын нэгдсэн төв | ЦДЦАБ |
| | | 2.3.Байгууллагын хариуцдаг, хамтран ажилладаг бизнесийн байгууллага, үйлчилгээ авдаг хуулийн этгээд, иргэн, Төрийн бус байгууллагуудад авлигаас урьдчилан сэргийлэх, ил тод байдлыг сайжруулах, ёс зүйг дээшлүүлэх, үйл | -Өөрсдийн нөөц бололцоонд тулгуурлан зохион байгуулах.<br>-Нотломж ирүүлсэн байх. | Байнга | Экологийн цагдаагийн алба | ЦДЦАБ |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | ажиллагааны хүнд суртлыг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, түүний үр дүнг мэдээлэн сурталчлах арга хэмжээг зохион байгуулах. | | | | |
| | | 2.4.Алба хаагчдын авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаарх мэдлэгийг баталгаажуулах зорилгоор цахим шалгалтын ажлыг зохион байгуулж, дүнг тухай бүр удирдлагад танилцуулах. | - Хамрагдсан алба хаагчдын тоо<br>- Чанар ахисан байх. | Улирал тутамд | Хуулийн хэлтэс | ЦДЦАБ |
| *Зорилт-3: Авлигын эсрэг үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бий болгох.* | | | | | | |
| 3. | Авлигын эсрэг үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бий болгох. | 3.1.Төрийн байгууллага, хувийн хэвшлийн хооронд байгуулах аливаа гэрээ хэлэлцээрт авлигаас урьдчилан сэргийлэх асуудлыг тусгах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авсан байх. | - Байгуулсан гэрээ бүрт авлигаас ангид байх асуудлыг тусгасан байх.<br>-Авлигыг мэдээлэх үүргийг тусгасан байх.<br>-Гэрээг цуцалсан тохиолдолд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх асуудлыг тусгах.<br>-Хэрэгжилтийн ач холбогдлыг үнэлж дүгнэсэн байх.<br>-Нотломжийг ирүүлсэн байх. | Тухай бүрд | Хуулийн хэлтэс Санхүү, аж ахуйн алба | ЦДЦАБ |
| | | 3.2.Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журам”-ыг хэрэгжүүлэх.<br>/*Засгийн газрын 2021 оны 109 дүгээр тогтоолын хавсралт*/ | -Олон нийтийн хяналтад хамруулах чиглэлийг тодорхойлсон байх.<br>-Сургалт мэдээлэл авсан байх.<br>-Хяналтын чиг үүргийг гүйцэтгүүлэх, | | Дотоод хяналт-Аюулгүй байдлын газар | ЦДЦАБ |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | тайлан зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлсэн байх. | | | |
| | | 3.3.Журмын 2.1.1 дэх заалтын хэрэгжилтийг хангах. /Мэдээллийн нээлттэй ил тод байдал/ | -Арга хэмжээг хэрэгжүүлэн, биелэлтийг нотломжийн хамт ирүүлэх. | Тухай бүрт | Хэвлэл, мэдээллийн төв | ЦДЦАБ |
| | | 3.4.Журмын 2.1.2 дахь заалтын хэрэгжилтийг хангах. /Шилэн дансны ил тод байдал/ | | | Дотоод хяналт-Аюулгүй байдлын газар | ЦДЦАБ |
| | | 3.5.Журмын 2.1.3 дахь заалтын хэрэгжилтийг хангах. /ГХУСТХуулийн 34, 36, 38,39 дүгээр зүйл / | | | Урьдчилан сэргийлэх хэлтэс | |
| | | 3.6.Журмын 2.1.4 дахь заалтын хэрэгжилтийг хангах. /Авлигын эсрэг хуулийн 5.1, 6.1 дэх заалтын буюу Төрийн байгууллагын хүлээх нийтлэг үүрэг/ | | | Дотоод хяналт-Аюулгүй байдлын газар | ЦДЦАБ |
| | | 3.7.Удирдлагын шийдвэрийн ил тод, нээлттэй байдал /тушаал, захирамж/ | - Цахим хуудсанд байршуулсан байх. | Жилдээ | Төлөвлөлт, зохион байгуулалтын хэлтэс | ЦДЦАБ |
| | | 3.8.Хүний нөөцийн томилгооны ил тод байдал, шагнал урамшууллын шударга байдлыг нэмэгдүүлэх, нөлөөллийг багасгах алба хаагчдыг мэдээллээр хангах зорилгоор алба хаагчийн бүртгэлтэй цахим шуудангийн хаягаар хэрхэн шийдвэрлэсэн талаар шийдвэр гарсан даруйд мэдээлж байх. | - Томилгоо, шагнал урамшууллын материал нь хэрхэн шийдэгдсэн талаар цахим шуудангаар алба хаагчдад хүргэгдсэн байх. | Жилдээ | Хүний нөөцийн хэлтэс | ЦДЦАБ |
| | | 3.9.Авлигатай тэмцэх газраас хүргүүлсэн “Зөвлөмж”-ийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллах. */Монгол Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн Ажлын албаны дарга бөгөөд ажлын хэсгийн нарийн бичгийн дарга Л.Нямгэрэлээс 2022 оны 2/44 албан бичгээр ирүүлсэн Авлигын эсрэг* | -Арга хэмжээг хэрэгжүүлэн хариу тайланг нотломжийн хамт хүргүүлсэн байх. | Жилд | Мөрдөн байцаах алба | Зөвлөмжийн заалтуудыг хариуцсан нэгжүүдээс нэгтгэж ирүүлэх. |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | *Үндэсний чуулганаас гарсан зөвлөмжийн биелэлтийг хангаж ажиллах./* | | | | |
| *Зорилт-4 : Авлига, ашиг сонирхлын зөрчил үүсгэх шалтгаан, нөхцөлийг арилгуулах арга хэмжээ авах чиглэлээр* | | | | | | |
| 4. | Авлига, ашиг сонирхлын зөрчил үүсгэх шалтгаан, нөхцөлийг арилгуулах арга хэмжээ авах | 4.1.Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх (үйлчилгээг цахимжуулах, шат дамжлага бууруулах, ил тод байдлыг нэмэгдүүлэх, гомдол мэдээлэлд дүн шинжилгээ хийж, асуудлыг шийдвэрлүүлэх, эрсдэлийн үнэлгээ хийлгэх г.м. | -Үйл ажиллагаанд эрсдэлийг тодорхойлж, урьдчилан сэргийлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч, үр дүнг тооцсон байх;<br>-Тайланд нотломжийг хавсаргасан байх. | 1 дүгээр улиралд | Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын алба | |
| | | 4.2.Салбарын хэмжээнд авлигаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг тодорхойлох, хүнд суртлыг бууруулах чиглэлээр хэлэлцүүлэг, уулзалт зохион байгуулж, шалтгаан нөхцөлийг арилгасан байх. | -2-оос доошгүйг зохион байгуулсан байх;<br>-Хэлэлцүүлэг, уулзалтын үр дүнд арга хэмжээ зохион байгуулсан байх;<br>-Тайланд нотломжийг хавсаргасан байх. | Хагас, бүтэн жил | Нийслэлийн цагдаагийн удирдах газар | ЦДЦАБ |
| | | 4.3.Үйлчлүүлэгчдээс авлигын эрсдэл, үйл ажиллагааны хүндрэл бэрхшээлийг тодорхойлох сэтгэл ханамжийн судалгаа авч, судалгааны дүгнэлтэд тулгуурлаж арга хэмжээ зохион байгуулах. | -Бодитой үр дүнг тооцсон байх;<br>-Тайланд нотломжийг хавсаргасан байх | Хагас, бүтэн жил | Дотоод хяналт-Аюулгүй байдлын газар | |
| | | 4.4.Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан “Ашиг сонирхлын зөрчлийг мэдэгдэх, тайлбарлах”, 9 дүгээр зүйлд заасан “Албан үүрэгт хөндлөнгөөс нөлөөлөх байдлыг | - Алба хаагчдад мэдээлэл хүргүүлсэн байх.<br><br>- Цахим шалгалтын асуултад оруулах. | Тухай бүр | Дотоод хяналт-Аюулгүй байдлын газар | ЦДЦАБ |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | мэдэгдэх тухай” заалтыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж хэвшүүлэх. | | | | |
| | | 4.5.Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдах авлигын эсрэг тогтвортой байдлыг үнэлэх сорилыг худалдан авч нутагшуулж, нэвтрүүлэх.<br>/ЦБХХ-ийн 3.2.5.6, ЦДЦБ-ын ГТ-ний 4.1.1 дэх заалт/ | -Алба хаагчдын 10 хүртэл хувийг сорилоор тандан судалсан байх; | Тухай бүр | ДХ-АБГ-ын Эрүүл мэнд сэтгэл зүйн тасаг | |
| *Зорилт-5: Байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл, санаачилга өрнүүлэх* | | | | | | |
| | Байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл, санаачилга өрнүүлэх | 5.1.Байгууллагын удирдлагын зүгээс 2023 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт, хүрсэн үр дүнг жилийн эцсээр нийт албан хаагчдадаа танилцуулах. | -Танилцуулах арга хэмжээг зохион байгуулсан байх;<br>Албан хаагчдаас гаргасан санал санаачилгыг хэлэлцсэн байх;<br>-Тайланд нотломжийг хавсаргасан байх. | Жилдээ | Дотоод хяналт-Аюулгүй байдлын газар | НЦУГ, Албад |
| | | 5.2.Авлигатай тэмцэх газраас дүрэм журам, ёс зүйн дүрмийн төсөлд өгсөн санал, зөвлөмжийг тусгасан байдал. | -Санал тусгасан байх;<br>-Тайланд нотломжийг хавсаргасан байх. | Жилдээ | Дотоод хяналт-Аюулгүй байдлын газар | |
| | | 5.3.Удирдлага салбар, нэгж, байгууллагын хүрээнд авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр санаачлан хийх ажил, арга хэмжээг нэмж төлөвлөн, тайлагнах. | -Төлөвлөгөөг баталж, олон нийт танилцах боломжоор хангасан байх;<br>-Тайлагнасан байх. | Тухай бүрт | Экологийн цагдаагийн алба | ЦДЦАБ |

Арга зүй: - Хариуцан хэрэгжүүлэх байгууллага нь хамтран хэрэгжүүлэх анги, байгууллагаас нэгдсэн тоо болон бусад мэдээллийг нэгтгэн дүгнэж, Дотоод хяналт-Аюулгүй байдлын газарт хагас, бүтэн жилээр ирүүлэх.

- Анги, байгууллагууд заагдсан ажил, арга хэмжээг бусад хамаарах төлөвлөлтүүддээ уялдуулан салбар төлөвлөгөө гарган хэрэгжүүлж ажиллахад анхаарах.
- Төлөвлөгөөний 5.3 дахь заалтын хүрээнд нэмж хийгдсэн ажлыг дүгнэхдээ нэмэлт оноогоор үнэлнэ.

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР